



Их Алтайн их, дээд сургуулиудын ректоруудын зөвлөл бүс хоорондын нэгдлийн дүрэм

Их Алтайн их, дээд сургуулиудын ректоруудын зөвлөл (цаашид «Зөвлөл» гэх) нь «Алтай - бидний нийтийн гэр» Олон улсын зохицуулах зөвлөлийн үйл ажиллагаанд оролцогч тус бүс нутгийн их, дээд сургуулиудын удирдлагуудын сайн дурын албан ёсны бус нэгдэл юм. Зөвлөл нь байнгын ажиллагаатай байгууллага болох «Алтай - бидний нийтийн гэр» Олон улсын зохицуулах зөвлөлийн хил орчмын хамтын ажиллагааны бүсийн нэгдлийн дүрмийн 13-р зүйлд заасны дагуу байгуулагдсан болно.

Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн чиглэлүүд «Их Алтайн их, дээд сургуулиудын ректоруудын зөвлөл» хэмээх бүс хоорондын нэгдлийг үүсгэн байгуулах тухай «Алтай - бидний нийтийн гэр» Олон улсын зохицуулах зөвлөлийн үйл ажиллагаанд оролцогч тус бүс нутгийн тэргүүлэх их, дээд сургуулиудын хамтын ажиллагааны Тунхаглалд тусгалаа олсон болно.

1 дүгээр зүйл

Зөвлөлийн оролцогчид нь Тунхаглалыг хүлээн зөвшөөрч гарын үсэг зурсан тус бүс нутгийн тэргүүлэх их, дээд сургуулиуд болно. Үүнд:

Алтайн хязгаар нутаг (ОХУ);

Баян-Өлгий аймаг (Монгол улс);

Ховд аймаг (Монгол улс);

Алтайн Бүгд найрамдах улс (ОХУ);

Шинжиан Уйгарын өөртөө засах орон (Бүгд найрамдах Хятад ард улс)

2 дугаар зүйл

Зөвлөл нь хуулийн этгээдийн статусгүй байгууллага болно.

Зөвлөлийн оролцогчид түншлэлийн зарчимд тулгуурлан өөрийн улсын хууль тогтоомжийн дагуу, бусад хамтрагч орны хууль, эрх зүйн хэм хэмжээг харгалзан хамтарсан төслүүд боловсруулж хэрэгжүүлнэ.

Зөвлөлийн оролцогч гадаадын бусад байгууллагатай гэрээ байгуулан ажиллахыг хориглохгүй.

Зөвлөл эрх хэмжээнийхээ хүрээнд бүс нутгийн хөгжлийн чиглэлээр хамтран хэрэгжүүлж болох төсөл хөтөлбөр боловсруулах, ажлын хэсгийн үйл ажиллагааг зохицуулах, төрийн байгууллагуудтай тогтоох холбоо, харилцааг дэмжих зэрэг нийтлэг чанартай, зарчмын шинжтэй асуудлуудыг шийдвэрлэнэ.

3 дугаар зүйл

Зөвлөлийн бүтэн нэр нь орос хэл дээр - Межрегиональное объединение «Совет ректоров вузов Большого Алтая»

Зөвлөлийн бүтэн нэр нь англи хэл дээр - Interregional Association «Grand Altai Council of HEI Chancellors»

Зөвлөлийн товчилсон нэр нь орос хэл дээр- Совет вузов Большого Алтая

Зөвлөлийн товчилсо нэр нь англи хэл дээр – GACC

Зөвлөлийн нэрийг Зөвлөлийн оролцогчид өөр өөрийн улсын хэл дээр хөрвүүлэн хэрэглэж болно.

4 дүгээр зүйл

Зөвлөлийн оролцогчид нь «Алтай» Олон улсын зохицуулах зөвлөлийн оролцогч - тус бүс нутгийн боловсролын удирдах дээд байгууллагууд, тэргүүлэх их, дээд сургуулиуд, мэргэжлийн боловсрол олгох байгууллагуудын удирдлагууд болон тэдгээрийн онцгой эрхт төлөөлөгчид байна.

Түүнчлэн дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэх асуудлыг бүрэн дүүрэн, олон талаас нь авч үзэж хэлэлцэх үүднээс «Алтай» Олон улсын зохицуулах зөвлөлийн зөвшөөрлөөр Зөвлөлийн бүрэлдэхүүнд Их Алтайн бүсийн ашгийн болон ашгийн бус байгууллагуудын удирдах ажилтан, олон нийтийн байгууллагуудын төлөөлөл оролцож болно.

5 дугаар зүйл:

Зөвлөлийн зорилго зорилт нь:

5.1. Дээд боловсролын чанарыг дээшлүүлэх, дээд боловсрол эзэмших дур сонирхлыг нэмэгдүүлэх, Их Алтайн нутаг дэвсгэрт орших их, дээд сургуулиудын хоорондын харилцааг сайжруулах;

5.2. Хамтарсан боловсрол, тэр дундаа хос болон олон дипломын боловсрол, эрдэм шинжилгээ, судалгааны хөтөлбөр хэрэгжүүлэх, соёл спортын арга хэмжээ зохион байгуулах;

5.3. Дээд боловсрол олгох, магистрантур, докторантурт сургах замаар шинжлэх ухаан, боловсролын салбарын боловсон хүчин бэлтгэх, Их Алтайн сургалтын байгууллагуудад багш нарын мэргэжил дээшлүүлэх зэргээр Талууд боловсрол шинжлэх ухааны салбарт хамтран ажиллах;

5.4. Бүс нутгаас зөвлөлд оролцогч их, дээд сургуулиуд, албан газрууд, компани, түүнчлэн бүсийн сургалтын байгууллагын боловсрол, шинжлэх ухааны ажилтан- хувь хүний эрэлт хэрэгцээг судлах;

5.5. Боловсрол, шинжлэх ухааны салбарын олон улсын хамтын ажиллагааны ирээдүйтэй чиглэл, хэлбэрийг олж илрүүлэх;

5.6. Бүсийн их, дээд сургуулиудын олон улсад хүлээн зөвшөөрөгдөх нөхцлийг хангахын тулд төгсөгчдийн мэргэжлийн чадвар, сургалтын түвшний жишиг, хөрвөх чанарыг дээшлүүлэх;

5.7. Орчин үеийн хөдөлгөөнт сургалтын хэлбэрийг хөгжүүлэх зорилгоор суралцагч, багш, мэргэжилтнүүдийг солилцох ажлыг зохион байгуулах;

5.8. Оролцогчдын боловсрол, шинжлэх ухаан, соёлын хамтын ажиллагааг дэмжих мэдээллийн бааз байгуулах;

5.9. Бүс нутгийн улсууд хоорондоо болон бусад орнуудтай олон улсын харилцаагаа хөгжүүлэх зорилгоор суртчилгаа, хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа явуулах;

5.10. Улс хоорондын болон олон улсын байгууллага, сангуудтай харилцаа тогтоох талаар хамтарсан судалгаа явуулах;

5.11. Эрдэм шинжилгээ, сургалтын хамтарсан төсөл, хөтөлбөр боловсруулах, тэдгээрт хяналт шинжилгээ хийх талаарх олон улсын болон үндэсний туршлагыг судлах чиглэлээр хамтран ажиллах;

5.12. Дээд боловсрол олгох, төгсөлтийн дараах сургалт эрхлэх чиглэлээр болон шинжлэх ухааны асуудлуудаар хамтарсан хурал, семинар зохион байгуулах, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хамтран явуулах.

6 дугаар зүйл

Дээрх зорилго, зорилтоо хэрэгжүүлэхийн тулд:

Алтай –бидний нийтийн гэр олон улсын зохицуулах зөвлөл тус бүс нутгийн их, дээд сургуулиудын хамтын ажиллагааны ирээдүйтэй чиглэлүүдийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Алтайн бүсийн засаг захиргаа, орон нутгийн байгууллага хоорондын боловсрол, шинжлэх ухаан техник, соёлын болон бусад салбарын харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэхэд дэмжлэг, туслалцаа үзүүлнэ.

7 дугаар зүйл

Зөвлөл оролцогчдынхоо хамтын ажиллагааг Тунхаглалд заагдсан бүхий л үйл ажиллагааны чиглэлээр зохион байгуулна

Оролцогчид өөрийн сургуулийн үйл ажиллагааны бүх нийтийг хамарсан шинж чанартай үйл ажиллагааны талаар мэдээлэл солилцоно.

8 дугаар зүйл

«Алтай-бидний нийтийн гэр» Олон улсын зохицуулах зөвлөлийг тухайн үед даргалж буй бүсийн аль нэг их, дээд сургуулийн удирдлага Зөвлөлийн удирдагчаар (Зөвлөлийн дарга) ажиллана. Зөвлөлийн дарга, орлогч даргад нэр дэвшигчдийг (янз бүрийн бүсээс нэр дэвшүүлж болно) Зөвлөлийн хурлаар олонхийн саналаар батлана.

9 дүгээр зүйл

Зөвлөлийн хамтын удирлагын дээд байгууллага нь түүний хурал байна.

Хурлаар зөвлөлийн хэтийн зорилго, ойрын үйл ажиллагааны зорилтуудыг боловсруулна.

Зөвлөлийн шийдвэрийг «Алтай-бидний нийтийн гэр» Олон улсын зохицуулах зөвлөлийн нарийн бичгийн дарга нарын газартай хэлэлцэн тогтоно.

Хурал дараах асуудлуудаар шийдвэр гаргана:

- дүрэм, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтүүдийг хэлэлцэж батлах;
- байнгын болон зорилтот ажлын хэсэг байгуулах;

- Зөвлөл, түүний ажлын хэсгийн (зорилтот) үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох;
 - Зөвлөлийн ажлын төлөвлөгөөг батлах;
 - ажлын хэсгүүдийн ахлагчдын тайланг сонсож хэлэлцэх;
 - хамтарсан төсөл, хөтөлбөр, арга хэмжээг батлах, тэдгээрийг санхүүжилтээр хангах;
 - Зөвлөлд шинээр гишүүн элсүүлэх, гишүүнчлэлээс хасах шийдвэр гаргах;
 - Зөвлөлийн үйл ажиллагааг зогсоох шийдвэр гаргах.
- Зөвлөл өөрийн үйл ажиллагаанд хамаарах бусад аливаа асуудлуудыг авч үзэж, хянан шийдвэрлэх эрхтэй.

10 дугаар зүйл

Зөвлөлийн хурал жилд нэг удаа, харин 2 жилд нэгээс цөөнгүй удаа явагдана.

Дараагийн ээлжит хурал «Алтай-бидний нийтийн гэр» Олон улсын зохицуулах зөвлөлтэй хэлэлцэн тогтсон ажлын төлөвлөгөөнд үндэслэн явагдана. Ээлжит бус хурал зөвлөлийн даргын санаачлагаар явагдана.

Зөвлөлийн хурал нь гурван орны оролцогчдоос бүрдсэн 50 –иас дээш хувийн ирцтэй байхад явагдана.

Зөвлөлийн оролцогч тус бүр нэг санал өгөх эрхтэй. Зөвлөл шийдвэрээ хуралд хүрэлцэн ирсэн оролцогчдын төлөөллийн зөвшилд үндэслэн гаргана.

11 дүгээр зүйл

Зөвлөлийн дарга:

- Зөвлөлийг зарлан хуралдуулна;
- Зөвлөлийн явцын ажлыг удирдан, Зөвлөлийн шийдвэрийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагааг зохицуулна;
- Зөвлөлийн нэрийн өмнөөс хурлын шийдвэр болон бусад баримт бичигт гарын үсэг зурна;
- Хурлыг даргалан явуулна;
- Зөвлөлийн эрх ашгийг төр засгийн байгууллагад төлөөлнө;
- энэхүү дүрэмд тодорхойлон заасны дагуу Зөвлөлийн хөрөнгийг захиран зарцуулна;

Өөрийн бүрэн эрхийн хүрээнд бусад үүргийг гүйцэтгэнэ.

12 дугаар зүйл

Зөвлөлийн зорилтыг хэрэгжүүлэхийн тулд түүний бүрэлдэхүүнд орсон их, дээд сургуулиудаас байнгын болон ажлын (зорилтот) хэсгийг зохион байгуулна. Байнгын болон ажлын (зорилтот) хэсэгт Зөвлөлийн оролцогч байгууллагын төлөөллөөс гадна тодорхой салбарын болон шинжлэх ухаан, олон нийтийн байгууллагын төлөөлөл, албан хүрээний хүмүүс орж болно. Зөвлөлийн хурал хоорондын ажлын хэсгүүдийн үйл ажиллагааны зохицуулалт, хяналтыг И. И. Ползуновын нэрэмжит Алтайн техникийн их

сургууль дээр ажилладаг Баруун Сибирийн их дээд сургуулиудын олон улсын хамтын ажиллагааны бүсийн төв (ОУХАБТ) гүйцэтгэнэ. Төвийн албан ёсны хаяг:

656038, ОХУ, Алтайн хязгаар нутаг, Барнаул хот, Лениний өргөн чөлөө, 46, утас: +7-3852-260-542, факс: +7-3852-260-496

e-mail: nikonov@mail.altstu.ru

Зөвлөлийн хурлын бэлтгэлийг «Алтай бидний нийтийн гэр» Олон улсын зохицуулах зөвлөлийг тухайн үед даргалж буй тал гүйцэтгэнэ.

13 дугаар зүйл

Зөвлөлийн хурал түүнийг зохион байгуулж буй улсын хэл дээр явагдана. Энэ үед хурлыг зохион байгуулагч тал хуралдааны явцыг бусад улсаас хуралд оролцогчдын хэл рүү орчуулан хүргэх ажлыг гүйцэтгэнэ.

14 дүгээр зүйл

Зөвлөлийн үйл ажиллагаа Зөвлөлийн гишүүн их, дээд сургуулиудын үйл ажиллагаагаар хангагдана.

Зөвлөлийн үйл ажиллагааг хангах зорилгоор төр захиргаа, орон нутгийн удирдах байгууллагууд, их, дээд сургуулиудад шаардлагатай материал, санхүүгийн нөөц бий болгож өгч болно.

Хуралд оролцох, ажлын хэсэгт ажиллах төлөөлөгчдөд шаардагдах зардлыг Зөвлөлийн оролцогч бие даан санхүүжүүлнэ.

Хуралд бэлтгэх, хуралдааныг явуулах зардлыг ээлжит хурлыг зохион байгуулж буй тал гаргана.

Хамтарсан төсөл хэрэгжүүлэх зорилгоор Зөвлөл нэгдсэн сан байгуулж болно. Сан байгуулах шийдвэр Зөвлөлийн хурлаар хэлэлцэгдэж батлагдана.

15 дугаар зүйл

Зөвлөлд шинэ гишүүн элсүүлэх асуудал байнга нээлттэй байна. Гишүүнээр элсэх, гишүүнчлэлээс хасагдах асуудлын аль аль нь тухайн их дээд сургууль бичгээр өргөдөл гаргах замаар шийдвэрлэгдэнэ /зөвлөлийн даргад хандан мэдэгдэх бичиг өгөн Зөвлөлийн бусад оролцогчдын сонорт хүргэнэ/. Гишүүнээр элсүүлэх, гишүүнээс хасах шийдвэр Зөвлөлийн ээлжит хурлаар олонхийн саналаар батлагдана.

16 дугаар зүйл

Оролцогчид гишүүнчлэлээс хасагдаж явсаар зөвхөн хоёр улсын засаг захиргааны байгууллага, их, дээд сургуулийн төлөөлөл үлдсэн тохиолдолд Зөвлөл үйл ажиллагаагаа зогсооно.